

МОНГОЛ УЛС БОЛОН БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГ, ХУДАЛДААНЫ ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

*Н. Улаан-Од**

Хорин нэгдүгээр зуунд урт хугацаанд тогтвортой, эрүүл саруул, харилцан итгэлтэй, хөрш улсын найрсаг харилцааг үргэлжлүүлэн хөгжүүлэх үүднээс БНХАУ-ын дарга Ху Жиньтао 2003 оны 6-р сард Монгол Улсад, Монгол Улсын ерөнхийлөгч Н.Энхбаяр 2005 оны 11-р сард БНХАУ-д төрийн айлчлал хийсэн явдал нь хоёр улсын улс төр, эдийн засаг худалдаа, соёл урлаг, боловсрол шинжлэх ухааны хамтын ажиллагааны харилцаанд маш чухал ач холбогдолтой болсон бөгөөд нэн ялангуяа хоёр орны худалдаа, эдийн засгийн салбарт ашигтай нөхцөл бололцоог бүрэлдүүлж өгсөн юм.

Нэг. Хоёр талын эдийн засгийн харилцаа

1. Хөрөнгө оруулалт, худалдаа, мөнгөн гүйлгээний хамтын ажиллагаа тасралтгүй дээшилж байна.

2005 он хүртэл БНХАУ долоон жил дараалан Монгол Улсад хөрөнгө оруулсан хэмжээгээрээ тэргүүн байрыг эзэлж, Монгол Улсад гадаадаас оруулсан хөрөнгийн хэмжээний 40 хувийг эзлэв. Одоо Монголд БНХАУ-ын 2000 гаруй аж ахуйн нэгж эдийн засаг худалдааны үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэрбум төгрөгөөс дээш хөрөнгө оруулсан аж ахуйн нэгж арав гаруй байна. Хөрөнгө оруулалт нь уул уурхай, оёмол сүлжмэл, барилгын материал, малын ашиг шимийг боловсруулах зэрэг олон салбарыг хамарчээ. Одоо Монгол Улс экспортын 51 хувь, импортын 27 хувийг БНХАУ-тай хийж байна.

2005 оны 5-р сард Монгол Улсын банк нь Хятадын Гадаадал гаргах итгэмжит зээл даатгалын групптай хамтын ажиллагааны гэрээ хийж, Хятадын тал Монголын талд 3 жилийн хугацаатай нийт 1 дүнчүүр ам.долларын итгэмжит зээл өгч, хоёр улсын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг дэмжин туслахаар тохиролцов.

2. Туршлага солилцох, үзэсгэлэн гаргах үйл ажиллагаа олширч байна.

2005 оны 5-р сард БНХАУ-ын Худалдааны хэргийн яам нь Монгол Улсын Үйлдвэр, худалдааны яамтай хамтран Улаанбаатарт “Монгол Улс болон БНХАУ-ын худалдааны явдлын ярилцааны индэр”-ийг эрхэлж, БНХАУ-ын Худалдааны хэргийн яам болон Эрүүл

* Н.Улаан-Од - БНХАУ-ын Өвөр Монголын Их сургуулийн Хөрш орон судлалын хүрээлэнгийн судлаач

хамгаалалын яамны дэд сайдууд хуралд оролцжээ. Хоёр тал Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин, эрчим хүч, уул уурхайн салбарын хөгжлийн байдал, эдийн засаг, худалдаа, мөнгөн гүйлгээ, барилга байгууламж, холбоо харилцаа зэрэг салбарт нягт хамтран ажиллах тухай ярилцан тохирсон байна.

2005 оны 6-р сарын 21-ний өдөр Монгол, Хятадын худалдааны байгууллагууд хамтран “БНХАУ-ын нэрт шилдэг бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, хөрөнгө оруулалтын уулзалт” арга хэмжээг зохион байгуулж, хоёр талын аж ахуйн нэгжийн хооронд хийгдсэн гэрээний мөнгөний хэмжээ нь 76000 мянган юаньд хүрчээ.

2005 оны 8-р сард Орос, Монгол, Хятадын хөрш зэргэлдээ бүс нутгийн эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаагааг эрчимжүүлэх зорилгоор туршлага солилцох семинарыг Улаанбаатар хотноо зохион байгуулж зохих үр дүнд хүрсэн юм.

3. Монгол Улсын эдийн засагт үзүүлэх БНХАУ-ын тусламжийн хэмжээ тасралтгүй нэмэгдэж байна.

2005 онд Ху Жиньтао дарга Монгол Улсад айлчлахдаа 50000 мянган юаний буцалтгүй тусламж, 3 сая долларын худалдааны зээл өгнө гэж амалжээ. 2004 онд Монгол Улсын ерөнхийлөгч Н.Багабанди БНХАУ-д айлчлах үеэр Хятадын тал Монголын талд 50000 мянган юаний буцалтгүй тусламж үзүүлэхээр хэлэлцэн тохирсон бөгөөд 2005 онд Хятадын Төрийн явдлын дэд ерөнхий сайд Ү И Монгол Улсад айлчлахдаа 60000 мянган юаний буцалтгүй тусламж болон 2 дүнчүүр юаний зээл өгнө гэж тохиролцжээ.

4. Эрчим хүч, уул уурхайн салбарын хамтын ажиллагааны цар хүрээ улам өргөжиж байна.

Сүүлийн жилээс БНХАУ-ын эдийн засгийн эрчимтэй хөгжлийн хурдсаас шалтгаалан нүүрс, нефть, зэс, цайр, төмөр зэрэг байгалийн ашигт малтмалын хэрэгцээ маш ихээр шаардагдах болсон явдал нь уул уурхайн салбарт хоёр тал харилцан ашигтай нягт хамтран ажиллах нөхцөл бололцоог бий болгон өгч байна. Эдүгээ Хятадын болд төмрийн компанийхан 10 гаруй дүнчүүр юаний хөрөнгө оруулж, Монгол Улсын Сүхбаатар аймагт цайрын уурхай нээж ашиглалтад оруулсан байна. Хятадын Шэн Ли газрын тосны уурхайн компанийхан 10000 мянган долларын хөрөнгө оруулж, Монгол Улсын Зүүнбаянд газрын тосны уурхай нээж байна. Хятадын Да Чингийн газрын тосны уурхайн компанийхан 90000 мянган долларын хөрөнгө оруулж, Монгол Улсын Тамсагт газрын тосны уурхай нээж байна. 2005 оны 5-р сард Хятадын

Бугатын болд төмрийн компанийхан Монгол Улсын зарим аж ахуйн нэгжийнхэнтэй уурхай хайгуул шинжилгээ ба нээн ашиглах гэрээ байгуулж хоёр тал Сэлэнгэ аймгийн Баянголын төмрийн уурхайг нээн ашиглахаар байна.

2005 оны 8-р сард хоёр тал одоогоор хамгийн том хэмжээний хөрөнгө оруулсан төсөл болох Монгол, Хятадын хамтарсан Төмөртын цайрын уурхайг ашиглалтанд оруулав. Энэхүү төсөл амжилттай хэрэгжсэнээр Монголын тал улсдаа жилд 20 дүнчүүр төгрөгийн татвар тушаах боломжтой болохоор барахгүй шууд болон дам шугамаар нэлээд олон ажлын байр бий болох юм.

5. Зам харилцаа болон дэд бүтцийн салбар дахь хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж байна.

2004 оны 3-р сараас ӨМӨЗО-ы төв Хөххотоос Германы Франкбуртын хооронд төмөр замаар контейнороор бараа тээвэрлэх үйл ажиллагаа хийгдэж эхэлсэн юм. Энэхүү галт тэрэг нь Монголоос Оросын Сибирийн төмөр замд хүрэхэд 18 өдөр болох бөгөөд усан замаар бараа тээвэрлэхээс 40 өдрийн цаг хугацаа хэмнэдэг байна.

2005 оны 8-р сард нийт урт нь 720 км, ерөнхий хөрөнгө оруулалт нь 38 дүнчүүр юаний өртөг бүхий, Өвөр Монголын Баяннуур хотын Лин Хэ хотоос Цэхэ боомт хүртэлх төмөр замын бүтээн байгуулалтын ажил эхэлсэн юм. Уг төсөл ашиглалтанд орсноор Өвөр Монголын баруун хэсэг болон Монгол Улсын өмнөд хэсгийг холбох чухал гүүр болж, хоёр талын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг улам нэг алхам эрчимжүүлэх халуун цэг болох юм.

2005 онд БНХАУ-ын маш олон барилгын компаниуд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод хэдэн зуун мянган ам.метр талбай бүхий нийтийн орон суушны барилгын ажлыг хийсэн юм.

6. Бүс нутгийн хамтын ажиллагаа тасралтгүй хөгжиж, иргэдийн хоорондох харилцаа нэмэгдэж боомтын бүтээн байгуулалт эрчимжсэн байна.

2005 оны эцсээр Эрээнээс Замын-Үүд хүртэлх засмал зам ашиглалтад орсон бөгөөд хилийн боомтоор өнгөрөх барааг Х гэрлээр шалгах тоног төхөөрөмжийг угсран хэрэглэх болсон явдал нь боомтоор бараа нэвтрүүлэх хүчин чадлыг ихэд нэмэгдүүлсэн байна.

2005 оны 7-р сард Шилийн гол аймгийн Зүүн Хатавч боомт нь Өвөр Монголын олон улсын чанартай гуравдагч байнгын нээлттэй боомт болсон нь Өвөр Монгол болон Монгол Улсын Сүхбаатар аймаг, Хэнтий аймаг болон Дорнод аймгийн хоорондын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны цар хүрээг маш ихээр өргөтгөв.

2005 оны 7-р сарын дундуур Өвөр Монголын Баяннуур хот нь Монгол Улсын Өмнөговь аймагтай хамтран Ганцмод боомтоор дамжин өнгөрөх олон улсын жуулчлалын шугамыг нээжээ.

2005 оны 9-р сард Монгол, Хятад хоёр улсын Засгийн газраас “Аршаан Сүмбэрийн боомтын Нөмрөг голд гүүр тавих газрыг сонгон тогтоох санамж бичиг”-т гарын үсэг зурав. Энэхүү төслийн ажил амжилттай дуусвал Монгол Улсын Дорнод аймагт Номон хааны байлдааны талбарыг сонирхох аялал жуулчлалын шинэ салбарыг нээн хөгжүүлэх нөхцөл бололцоог бий болгох юм.

Үүнээс гадна 2004 онд Монгол Улсын Зам тээвэр, аялал жуулчлалын яамны төлөөлөгчид Америкийн Бойнг компанид очиж Бойнг-737-800 маркын нисэх онгоцыг хөлслөхөөр тохиролцож, 2008 оны Бээжингийн олимпын наадмын үеэр аялал жуулчлалын үйлсийг ихээр хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Хоёр. Хоёр талын эдийн засаг, худалдаанд оршиж байгаа асуудал ба бэрхшээл

Сүүлийн жилүүдэд Монгол, Хятадын эдийн засаг, худалдаа өдөр тутам өрнөн хөгжиж байгаа өөдрөг талыг олж харахын зэрэгцээ мөн өдий төдий асуудал, бэрхшээл оршиж байгаа сөрөг талыг ч олж харах хэрэгтэй юм. Үүнд:

1. Хятад, Монгол хоёр улс нь хэдийгээр ДХБ-ын гишүүн орон боловч хоёр улсын эдийн засаг, худалдааны тогтолцоо нь жинхэнэ утгаараа олон улсын эдийн засгийн зохицуулалт хууль дүрмийн дагуу бүх талаар явагдаж чадахгүй байгаа асуудал одоог хүртэл оршсоор байна.

2. Монгол Улсын уул уурхайн эх баялгийг хамтран нээн ашиглахад баталгаа муу байгаа бодит байдал амьдрал дээр ил харагдаж эхэллээ. Учир нь Монголд хувьчлалын төрийн бодлого хэрэгжсэнээс хойших сүүлийн арваад жилд хувь хүний гарт уурхай нээх лицензийн бичиг нь байдаг. Хэрэв уурхай нээх гэвэл урьдаар лицензийн бичиг эзэмшиж байгаа хүнтэй нь ярих хэрэгтэй, эзэн нь өгөх дуртай эсэх, ямар нөхцөл бололцоо шаардах асуудалд Засгийн газар нь гар дүрэх эрхгүй юм. Иймэрхүү байдал нь Хятадын талынханд нэлээд бэрхшээл учруулж байна.

3. Хятадын талын зарим аж ахуйн нэгж, хувь хүн Монгол Улсын нийгмийн өнөөгийн байдал, эрх зүйн орчин, арилжаа наймаа хийх нөхцөл бололцооны талаар сайн ойлголлтгүйгээс болж “сохроор” наймаа хийх хүмүүс маш олноор очиж байгаа явдал нь нэг талаар ашиг хонжоо олохгүй мөртлөө нөгөө талаар хүний нутагт эмх замбараагүй байдлыг үүсгэн,

тухайн газар орны иргэдийн дургүйцлийг хүргэх явдал нэлээд гарах боллоо. Эдийн засаг, худалдааны хэт халуунаас үүсэж байгаа тодорхой асуудлуудыг даруй түргэн шийдвэрлэхгүй бол хоёр улсын эдийн засаг, худалдааны харилцаанд муугаар нөлөөлөхөөр барахгүй цаашилбал улс төрийн харилцаанд ч эерэг бус үр дагаварыг бий болгож мэдэх юм.

4. Монгол Улсад бүртгэгдсэн Хятадын аж ахуйн нэгж 2000 гаруйд хүрсэн боловч жинхэнэ хүчин чадалтай, иптэл найдвар сайтай, хөрөнгө мөнгөтэй аж ахуйн нэгж нь маш цөөн байдаг. Нэн ялангуяа Монгол Улсад ажил хийхээр очиж байгаа олонхи хүмүүсийн соёл боловсролын түвшин нь нэлээд доор байдаг тул хоёр талын буюу өөр хоорондоо элдэв зүйлийн зөрчил маргаан гаргадаг. Эдгээр асуудлууд нь хоёр улсын эдийн засаг, худалдааг улам нэг алхам хөгжүүлэхэд зохих түвшинд саад болох нь мэдээж юм.

5. Монгол Улсад ажиллах мэргэжилтэнд хүний тооны хязгаартай байдаг мөртлөө тэнд ажиллах хөдөлмөрлөх хүчнээс сар бүр 49800 төгрөгийн ажлын байрны хураамж хураадаг явдал нь жижиг наймаачдын дараасыг ихээр нэмэгдүүлж байх юм.

6. Монгол, Хятадын худалдааны гол хэлбэр нь улсын худалдаа, бараа солилцох худалдаа, материал оруулж боловсруулах худалдаа, гаалийн баталгаат бүсэд барааг хил давуулах худалдаа, хил хязгаарын орон нутгийн худалдаа зэрэг олон зүйл байдаг. Эдгээр худалдааны салбарт нэг нэгнээ худал хэлэн мэхлэх, тогтсон цагтаа бараагаа нийлүүлэхгүй буюу бусдын барааг авч барьцаалах, хуурмаг чанар муутай бараа нийлүүлэх зэрэг асуудлууд зөндөө гардаг нь хоёр улсын худалдааны хэвийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байх бэрхшээлүүд оршиж байна.

Гурав. Хоёр талын эдийн засаг худалдааг эрчимжүүлэх тухай хэдэн санал

1. Монгол, Хятад хоёр улсын эдийн засаг, худалдааны салбар нь харилцан нөхөрлөх чанараар их байдаг онцлогийг үндэслэн, хоёр талын зах зээлийн эрэлт хэрэгцээ, нөхцөл бололцоог сайн нарийн судлах хэрэгтэй.

2. Монгол Улс бол манай улсын жил бүр нэмэгдэж байгаа шороон шуурга үүсэх голомтын нэг болжээ. Хэрэв бид зөвхөн нээн ашиглахыг нь чухалчлаад, тэдний байгаль орчныг нь хамгаалах асуудлыг давхар бодохгүй бол манай улсын экологийн нөхцөл бололцоог нэн ихээр муутгаж мэднэ.

3. БНХАУ-ын аж ахуйн нэгж Монгол Улсад хөрөнгө оруулахдаа зөвхөн ашиг их хүртэх уул уурхайн салбарт биш, аль чадахуйц бусад олон

шинэ салбарыг эрэн хайж хамтран ажиллахыг анхаарах мөртлөө Монгол Улсаар дамжин өрнө дахины зарим улсын аж ахуйн нэгжтэй холбоо тогтоон хамтын ажиллагаа өрнүүлж, хараагаа өргөтгөвөл зохино.

4. Монгол Улсын талаас удаа дараалан дурдаж байгаа манай улсын Тяньжинь усан боомтоор дамжин дэлхийн бусад улстай худалдаа хийх гэсэн хүсэл саналыг нь хүндэтгэн үзэх хэрэгтэй. Мөн Монгол Улс нь Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын ажиглагч улс болсоны хувьд Зүүн Хойт Азийн бүс нутгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцож, эдийн засгийн хамтын ажиллагаагаа улам эрчимжүүлье гэсэн зөв саналыг идэвхтэй дэмжих хэрэгтэй.

5. Монгол, Хятад хоёр улс нь зөвхөн эдийн засаг, худалдааны явцуу хүрээнд биш, соёл иргэншил, боловсрол, аялал жуулчлал, экологийг хамгаалах, гамшгаас аврах, эрүүлийг хамгаалах зэрэг олон салбарт хамтын ажиллагаагаа өргөтгөж, сайн хөршийн түншлэлийн харилцаагаа улам нэг алхам урагшлуулбал зохино.